



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Г Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Г
зааварчилгааг батлах тухай

Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Оффисын албан хаагчдын ажлын байранд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг нэгдүгээр хавсралт, үйлчлэгчийн ажлын байранд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан, өдөр тутмын ажилд нь хэвшүүлэн, хяналт тавьж ажиллахыг Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн /О.Уламбаяр/, нярав /Э.Ундармаа/-д, шаардлагатай хувцас, багаж хэрэгслийн норм үнэлгээг гарган мөрдүүлэх, хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Ц.Бямбасүрэн/-д тус тус даалгасугай.

ДАРГА

С.БАТЖАРГАЛ



000115

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк" ОНӨТҮГ-н даргын 2020
оны 07 сарын 29-ны өдрийн 1/29 тоот тушаалын
1 дүгээр хавсралт

**"НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ОНӨТҮГ-Н ОФФИСЫН АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА**

1. Ерөнхий шаардлага.

1) Энэхүү зааварчилгааг "НБМҮТГ" ОНӨТҮГ-н албан тасалгаанд болон гадна орчинд ажиллаж байгаа албан хаагчид, ажилтнууд, дадлагын болон туршилтын, хөлсөөр ажиллах гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа ажилтнууд дагаж мөрдөх бөгөөд ажлын байрны нөхцөлөөс шалтгаалан тухай бүрд нь нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2) Оффисын ажилтнууд дараах аюултай болон хортой хүчин зүйлийн нөлөөлөлд өртөж болохыг байнга анхаар. Үүнд:

- Ихэвчлэн шалны гадаргуугийн байдал буюу нойтон, хотгор гүдгэр зэрэг байдлаас болж бүдрэх, халтирах, унах, шатнаас ойчих
- Телевизор, толь, өндөрт байрласан тавиур зэрэг хананд зүүсэн эд зүйл бэхэлгээ муугаас унаж хагарах, зүсэгдэх
- Цахилгааны залгуур, монтажны утас ил байснаас нойтон зүйлтэй хүрэлцэн хүчдэлд цохиулах
- Зориулалтын бус химийн бодисыг цэвэрлэгээний болон бусад зориулалтаар хэрэглэснээс хордох
- Цахилгаан хэрэгслийг тэжээлийн эх үүсвэрээс салгаагүй орхисноос галын аюултай байдал үүсэх
- Цахилгаан хэрэгслийн хүчдэлийн хэмжээг буруу тооцоолон хэт их ачаалал өгснөөс цахилгааны утас шатах
- Хурц ирмэгтэй, үзүүртэй, эсвэл хэт хүнд, овор ихтэй багаж хэрэгсэлтэй ажиллахдаа тэдгээрийн нөлөөлөлд өртөж гэмтэх
- Температурын эрс тэс нөхцөл (хэт халуун, хүйтэн, гадаа, хөргүүр бүхий байр)-д ажиллахдаа хамгаалах хувцас, биеийн хэмийг тогтмол барих шингэн зүйлийг зориулалтын дагуу байнга хэрэглээгүйгээс биеийн байдал тавгүйрхэх
- Биологийн аюултай хүчин зүйлээс болгоомжилж, тэжээвэр амьтан, хачиг, бусад мэрэгч, шимэгч амьтанд хазуулах аюул байнга байдгийг санах
- Удаан хугацаагаар хөдөлгөөнгүй, буруу байрлалд сууснаар эргономикийн аюулд өртөх

- Компьютер болон хэвлэх, хувилах төхөөрөмжөөс гарч байгаа хорт туяа, бусад хортой хүчин зүйлийн нөлөөлөлд өртөх

3) Оффисын ажилтнууд дараах зүйлийг сайтар анхаарч, шууд удирдаж байгаа ажилтнуудад заавал мэдэгдэх үүрэгтэй.

- Ажил гүйцэтгэж байх үед биед ямар нэгэн зовиур мэдэгдэх, гэнэтийн осолд өртөх болон өөрийн эсвэл бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох аливаа нөхцөл байдал илрэх
- Аюултай орчинд, эрсдэлтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүст тусламж хэрэгтэй байх үед

2. Ажил эхлэхийн өмнөх үеийн зааварчилгаа.

1. Ажилдаа ирэхдээ хангалттай унтаж амарсан байх, хэт ядарсан нойргүй байдлаар ажлын байранд ажиллахгүй байх, цайны цаг буюу завсарлагааны цагийг мөрдөж ажиллах
2. Ажил эхлэхийн өмнө техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, цахилгааны доголдол, эвдрэл гэмтэл зэргийг тогтмол шалгаж хэвших
3. Өөрийн сууж ажиллах ширээ, сандлын өндөр намыг тохируулах
4. Цахилгаан хэрэгслийг залгах залгуурт хэт ачаалал өгөхгүй байх
5. Гэрэлтүүлгийг шалгаж, байгалийн гэрэлтүүлэг шаардлага хангахгүй байгаа үед өрөө тасалгааны гэрлийг асаах
6. Компьютерийн дэлгэц нь гэрэл ойлгохгүй зүгт харсан байх
7. Ажлын байрны шал, хана, таазны гадаргуу нь нойтон биш, ан цав гараагүй, тэгш эсэхийг шалгах
8. Ажиллах явцад дээрээс эд зүйл унах, асгарах, хажуугаас механик үйлчлэлээр нөлөөлөх зүйл байгааг шалгах
9. Та өмнө хийж байсан ажлын байрнаас өөр ажлын байранд шилжиж ажиллах бол тодорхойгүй зүйлсийн талаар удирдах ажилтнаас тодруулж асуух
10. Өрөө тасалгааг сайтар агааржуулсан байх

3. Ажил гүйцэтгэж байх үеийн зааварчилгаа.

1. Ажил гүйцэтгэх үедээ нүд, нуруунд ирж байгаа ачааллыг тооцоолох
2. Ажлын байрыг эмхэлж цэгцэлсэн, ажил хийхэд саад болох эд зүйл байгааг дахин ажиглах
3. Бүүдрэх, халтирах, толгойгоороо юм мөргөх, гараа хавчуулах, хөл дээрээ юм унагах, халуун зүйлд түлэгдэх, цахилгаан хүчдэл цохиулах зэрэг нь амь насаа ч алдаж болох эрсдэлд хүргэдэг гэдгийг байнга санах
4. Жин, овор ихтэй болон халуун зүйлийг хөдөлгөх, зөөхөөр бол тусламж хүсэх
5. Цахилгаан, тоног төхөөрөмжүүд, компьютерээс шингэн зүйлсийг хол байлгах

6. Түр хугацаагаар амрах үедээ янз бүрийн хайрцаг саван дээр суухгүй байх
7. Цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж ажиллуулахаар бол галын болон цахилгааны аюулгүй байдлын дүрэм, ажиллуулах заавар журмыг байнга мөрдөж ажиллах
8. Ус, бага үдийн цай зэрэг өөрийн гэрээс авчирсан хүнсний зүйлсийг муутгахгүй хадгалах, 4-с илүү цагаар тасалгааны температурт хадгалахгүй байх
9. Шүүгээний нүд, шургуулга зэргийг байнга хааж байх
10. Босож, суух үедээ цонхны салхивч, шургуулга зэрэг онгорхой орхисон эд зүйлд цохигдохоос сэргийлэх
11. Аль болох бусдын ажилд саад болохгүй, чимээ шуугиан гаргахгүйгээр ажлын зохицуулалт хийнэ
12. Таны ажилд шууд хамааралгүй ч бусдад аюултай, эрсдэлтэй хүчин зүйл илэрвэл удирдлагадаа шууд мэдэгдэнэ

4. Гадуур ажиллах үеийн зааварчилгаа.

1. Тодорхой удирдамжийн дагуу буюу судалгаа мэдээлэл хүргэх ажлаар аж ахуйн нэгж, байгууллагаар явж ажиллах үедээ цаг агаарын байдалд тохируулан хувцаслаж, өөрийн байгууллагатай утсаар холбоотой ажиллах
2. Таны эрүүл мэндэд гэнэтийн байдлаар хохирол учруулж болзошгүй тэнэмэл нохой, согтуурсан хүмүүс зэргээс болгоомжлох
3. Гадуур ажиллах үед замын байдлыг байнга анхаарч, ухсан нүх, цахилгааны гэмтэлтэй газардуулгагүй хэсэг хальтаргаатай зам болон дээрээс юм нурж унах эрсдлээс еерийгөө хамгаалж, урьдчилан сэргийлэх
4. Авто замын хөдөлгөөнд оролцох, зам хөндлөн гарах зэрэг үедээ зохих хууль, дүрэм журмыг сахин биелүүлэх
5. Иргэний болон ажлын үнэмлэх, ажлын зорилго тодорхойлсон албан тоот зэргийг сайтар бүрдүүлж биедээ авч явбал зохино.

5. Ажил дууссаны дараах зааварчилгаа.

1. Ажлын байраа эмхэлж цэгцлэх
2. Дараагийн хүн, дараагийн ээлж болон хоногт тухайн ажлын байранд ажиллахад бэлэн болгож үлдээх
3. Өөрийн ариун цэврийг сайтар хангах
4. Шаардлага хангахгүй болсон багаж, хэрэгсэл, тоноглолыг тухай удирдлагадаа мэдэгдэх

6. Оффисын орчинд галын аюулаас сэргийлэх.

1. Ажилтан, албан хаагчид оффисийн орчинд аливаа тэсэрч дэлбэрэх бодис авчрах хадгалахыг хориглоно
2. Албан тасалгаанд цахилгаан болон газан плитка ажиллуулахыг хориглоно

3. Ажилтан албан хаагчид тамхины хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах бөгөөд зөвшөөрөгдсөн газар тамхи татахдаа орчны цэвэр байдал, аюулгүй байдлыг хангаж хэвших, хогийн сав болон бусад зүйлд тамхины ишийг заавал шалгаж, унтрааж хэвших
4. Ажлаас тарахдаа цахилгааны хэрэгсэл /рс, принтөр/, гэрэл унтрааж, усаа хаах бөгөөд эргэж заавал шалгаж, өрөөний албан хаагчид нэгэндээ анхааруулж, сануулж хэвшил болгох
5. Ажлын бус цагаар оффист ажиллахыг аль болох татгалзах
6. Өөрийн болгоомжгүй, хайхрамжгүй, буруутай үйлдлээс болж галын аливаа осол, гэмтэл, хохирол гарсан тохиолдолд тухайн албан хаагч гаргасан зөрчил, хохиролыг хариуцан барагдуулах болохыг анхаарах

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк” ОНӨТҮГ-ын даргын 2020
оны... сарын...-ны өдрийн... тоот тушаалын
2 дугаар хавсралт

**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-Н ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА**

1. Ерөнхий шаардлага.

1) Энэхүү зааварчилгааг “НБМҮТП” ОНӨТҮГ-тай аливаа гэрээ багуулан ажиллаж байгаа үйлчилгээний болон туслах шинж чанартай ажил гүйцэтгэж байгаа ажилтнууд дагаж мөрдөх бөгөөд ажлын байрны нөхцлөөс шалтгаалан тухай бүрт нь нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2) Үйлчилгээний ажилтнууд дараах аюултай болон хортой хүчин зүйлийн нөлөөлөлд өртөж болохыг байнга анхаар. Үүнд:

- Цэвэрлэгээний орчин зүү, хадаас, хатгуур, хагархай шил гэх мэт хурц үзүүр, ирмэгтэй эд зүйл байж зүсэгдэх
- Шил толь гэх мэт хананд зүүсэн эд зүйл бэхэлгээ муугаас унаж хагарах, зүсэгдэх
- Цахилгааны залгуур, монтажны утас ил байснаас нойтон зүйлтэй хүрэлцэн хүчдэлд цохиулах
- Чулуун шал /ялангуяа өвлийн улиралд/ гэх мэт хатуу, гялгар гадаргуутай шал тавцан дээр халтирч унах
- Зориулалтын бус химийн бодисыг цэвэрлэгээний болон бусад зориулалтаар хэрэглэснээс хордох
- Цахилгаан хэрэгслийг тэжээлийн эх үүсвэрээс салгалгүй цэвэрлэгээ хийснээс цахилгаан хүчдэлд цохиулах
- Хурц ирмэгтэй, үзүүртэй, эсвэл хэт хүнд, овор ихтэй багаж хэрэгсэлтэй ажиллахдаа тэдгээрийн нөлөөлөлд өртөж гэмтэх
- Температурын эрс тэс нөхцөл (хэт халуун, хүйтэн, гадаа, хөргүүр бүхий байр)-д ажиллахдаа хамгаалах хувцас, биеийн хэмийг тогтмол барих шингэн зүйлийг зориулалтын дагуу байнга хэрэглэх
- Биологийн аюултай хүчин зүйлээс болгоомжил. Тэжээвэр амьтан, хачиг, бусад мэрэгч, шимэгч амьтанд хазуулах аюул байнга байдгийг санах

3) Үйлчилгээний ажилтнууд дараах зүйлийг сайтар анхаарч, шууд удирдаж байгаа ажилтнуудад заавал мэдэгдэх үүрэгтэй.

- Ажил гүйцэтгэж байх үед биед ямар нэгэн зовиур мэдэгдэх, гэнэтийн осолд өртөх болон өөрийн эсвэл бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох аливаа нөхцөл байдал илрэх

2. Ажил эхлэхийн өмнөх үеийн зааварчилгаа.

- 1) Тухайн ажлыг эхлэхийн өмнө зөвшөөрөл шаарддаг бол тухайн зөвшөөрлийг авах
- 2) Тусгай хэрэгсэл, ажлын багажийг шалгаж үзэх. Гэмтэлтэй, дутуу, иргүй, бохирлогдсон, шаардлага хангаагүй хувцас хэрэгсэл, багаж хэрэглэхгүй байх
- 3) Тухайн ажлыг гүйцэтгэхэд өөрийн тань ариун цэврийн байдал тохирч байгаа эсэхийг шалгаж үзэх. Тухайлбал үс, хумс, ээмэг, бөгж, шаардлагатай үед хормогч, хантааз хэрэглэх эсэх гэх мэт
- 4) Ажлын байрны гэрэлтүүлэг, ажлын явцад хэрэглэгдэх цахилгаан тоног төхөөрөмжүүд хэвийн эсэхийг шалгах
- 5) Ажлын байрны шал, хана, таазны гадаргуу нь нойтон биш, ан цав гараагүй, тэгш эсэхийг шалгах
- 6) Ажиллах явцад дээрээс эд зүйл унах, асгарах, хажуугаас механик үйлчлэлээр нөлөөлөх зүйл байгааг шалгах
- 7) Таны өмнө хийж байсан ажлаас өөр ажил хийх шаардлага гарвал удирдах ажилтнаас тодруулж асуух

3. Ажил гүйцэтгэж байх үеийн зааварчилгаа.

- 1) Ажил гүйцэтгэхдээ зөвхөн бүрэн бүтэн, зориулалтын багаж хэрэглэх
- 2) Ажлын байрыг эмхэлж цэгцэлсэн, ажил хийхэд саад болох эд зүйл байгааг дахин ажиглах
- 3) Бүдрэх, халтирах, толгойгоороо юм мөргөх, гараа хавчуулах, хөл дээрээ юм унагах, халуун зүйлд түлэгдэх, цахилгаан хүчдэл цохиулах зэрэг нь амь насаа ч алдаж болох эрсдэлд хүргэдэг гэдгийг байнга санах
- 4) Жин, овор ихтэй болон халуун зүйлийг хөдөлгөх, зөөхөөр бол тусламж хүсэх
- 5) Түр хугацаагаар амрах үедээ янз бүрийн хайрцаг саван дээр суухгүй байх
- 6) Ил гал гаргах, цахилгаан хэрэгсэл ажиллуулахаар бол галын болон цахилгааны аюулгүй байдлын дүрэм журмыг байнга мөрдөж ажиллах
- 7) Усны крант онгойлгох үедээ эхлээд бага гоожуул, халуун эсэхийг шалгахаар бол резинэн бээлий өмссөн гараар шалгах
- 8) Цэвэрлэгээг дараах дарааллаар хийх:
 - Цахилгаан тоноглолыг цэвэрлэх
 - Ширээ сандал цэвэрлэх
 - Цонх, хаалга цэвэрлэх
 - Шал цэвэрлэх
 - Гар угаагуур цэвэрлэх
 - Бие засах газар цэвэрлэх
- 9) Өрөө тасалгааг дараах дарааллаар цэвэрлэх:
 - Оффисын зориулалттай өрөө

- Хооллох зориулалттай өрөө
- Хоол боловсруулах хэсэг
- Хонгил, гарц, шат, үүдний хэсэг
- Ариун цэврийн хэсэг

- 10) Цэвэрлэгээний арчих материалыг энэ зааварчилгааны 3.8 дахь хэсэгт заасны дагуу тус бүрийн зориулалтын дагуу хэрэглэх бөгөөд хооронд нь холихыг хатуу хориглоно. Цэвэрлэх, арчих материалууд нь тус тусдаа өөр өөр өнгөтэй байхыг шаардана
- 11) Аливаа цэвэрлэх, ариутгах бодис, уусмалыг хэрэглэхдээ зөвхөн зориулалтын дагуу, түүний хаяг, зааварт заасан найрлага, орцоор хэрэглэнэ
- 12) Бодисыг үнэртэж, амсаж, зориулалтыг нь мэдэхгүй бол өөр зүйлд хэрэглэхийг хориглоно
- 13) Тааз, гэрлийн шил, бүрхүүл, өндөр давхрын цонх цэвэрлэж, шат, тавцан ашиглах үедээ зөвшөөрөл авч, хажуудаа хянах хүн байлгана
- 14) Аль болох бусдын ажилд саад болохгүй, чимээ шуугиан гаргахгүйгээр ажлын зохицуулалт хийнэ
- 15) Таны ажилд шууд хамааралгүй ч бусдад аюултай, эрсдэлтэй хүчин зүйл илэрвэл удирдлагадаа шууд мэдэгдэнэ

4. Ажил дууссаны дараах зааварчилгаа.

- 1) Ажлын байраа эмхэлж цэгцлэх
- 2) Дараагийн хүн, дараагийн ээлж болон хоногт тухайн ажлын байранд ажиллахад бэлэн болгож үлдээх
- 3) Өөрийн ариун цэврийг сайтар хангах
- 4) Шаардлага хангахгүй болсон багаж, хэрэгсэл, тоноглолыг тухай удирдлагадаа мэдэгдэх
- 5) Хог хаягдлыг заасан цэгт, ангилан хаях (*Түргэн муудах, эвгүй үнэр ялгаруулах, хоолны, дахин боловсруулах, цаасны, аюултай гэх мэт*)